



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 02 03, Факс: (976-11) 32 26 83,
Цахим шуудан: info@gazar.gov.mn

21 АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗАРТ

2025.04.10 № 1/1205
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Газрын тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6-д Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтлэг бүрэн эрхийн хүрээнд тухайн орон нутгийн онцлогт тохируулж, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журмыг батлахаар заасан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Дорнод Монголын хуурай хээрийн тогвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөлтэй хамтран “Бэлчээр ашиглах, хамгаалах, сайжруулах журам”-ын төслийг жишиг байдлаар боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

Тус журмыг батлан хэрэгжүүлснээр бэлчээр ашиглах, хамгаалах, сайжруулахад төрийн байгууллага, бэлчээр ашиглагчид (малчин өрх, малчдын анхдагч холбоо, нөхөрлөл, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч)-ын үйл ажиллагаа, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг нэгдсэн зохицуулалтаар хангах, бэлчээрийн зөрчил маргааныг шийдвэрлэх, маргаан үүсэхээс сэргийлэх, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах, доройтол, талхагдлыг бууруулах, цаашлаад уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны улмаас экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг сааруулах, мал аж ахуйн салбарт учрах байгалийн эрсдэлийг даван туулах чадавхийг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Иймд “Бэлчээр ашиглах, хамгаалах, сайжруулах журам”-ын төсөлд өөрийн орон нутгийн онцлог асуудлуудыг тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, батлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг хүсье.

Хавсралт 9 хуудастай.

ХУВИЙГ ЦАХИМ АААР:

1. АРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
2. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
3. БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
4. БУЛГАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
5. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
6. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
7. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
8. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
9. ДОРНОД АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
10. ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
11. ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
12. ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
13. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
14. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
15. СҮХБААТАР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
16. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
17. ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
18. УВС АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
19. ХОВД АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
20. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ
21. ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ

..... АЙМГИЙН БЭЛЧЭЭР АШИГЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. аймгийн нутаг дэвсгэрт бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэхүү журам нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай, Малчны тухай, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйлчилнэ.

1.3.Журмыг хэрэгжүүлснээр бэлчээр ашиглах, хамгаалахад төрийн байгууллага, бэлчээр ашиглагчид (малчин өрх, малчин өрхийн анхдагч холбоо, нөхөрлөл, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч)-ыг үйл ажиллагаа, үүрэг хариуцлагажуулах арга хэмжээг нэгдсэн зохицуулалтаар хангах, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах, доройтол, талхагдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны улмаас бэлчээрийн экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг сааруулах, мал аж ахуйн салбарт учрах байгалийн эрсдэлийг даван туулах чадавх дээшилнэ.

1.4. Энэ журмыг тус аймгийн сумдын нутаг дэвсгэрт бэлчээр ашиглаж байгаа малчин өрх, малчин өрхийн анхдагч холбоо дагаж мөрдөнө.

Хоёр. Бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд төрийн байгууллагууд, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1.Бүх шатны Засаг дарга энэхүү журамтай холбогдох чиг үүргийн дагуу дараах нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.1.Газрын тухай хуулийн 3.24.2 болон 3.24.3-д заасны дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийг жил бүрийн эхний улиралд багтаан байгуулж ажлын хэсгийг аймагт газрын албаны дарга, суманд Засаг даргын Тамгын газрын дарга ахалж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар аймгийн газар зохион байгуулалт, хот байгуулалтын газрын холбогдох албан тушаалтан, суманд сумын газрын даамлыг ажиллуулах;

2.1.2.Бэлчээр ашиглах, хамгаалах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, дүгнэх, тайлагнах;

2.1.3.Доод шатны Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус журмын хэрэгжилттэй холбогдох арга хэмжээнүүдийг тусгах, биелэлтийг хангуулах;

2.1.4.Бэлчээрийн ургац, даац, малын төрөл зүйл, зэрлэг амьтдын амьдрах орчныг харгалзан бэлчээрийг улирлын, отрын, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, түүнчлэн хорио цээрийн бэлчээр гэж ангилан ашиглалтыг зохицуулах;

2.1.5.Энэхүү журамд нийцүүлэн сумын бэлчээр ашиглах, хамгаалах журмыг боловсруулах ажлыг сумын Засаг дарга хариуцан гүйцэтгэх;

2.1.6. Газрын тухай хуулийн 58.5 дахь хэсэгт заасны дагуу аймгийн бэлчээр,

хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх санхүүжилт болон аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах арга хэмжээг тухай бүр авах;

2.1.7. Бэлчээрийн фотомониторингийн цэгийг шинээр сонгох, байршлыг өөрчлөх саналыг сумын Засаг даргын албан бичгээр аймгийн Газрын албанд хүргүүлэх.

2.1.8. Ган, зуд, байгалийн гамшигт үзэгдэл, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин нутаг дэвсгэрт нь гарсан тохиолдолд бэлчээр ашиглалттай уялдуулан отор нүүдэл хийх, хорио цээр тогтоох, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

2.1.9. Эрх бүхий байгууллагын үнэлгээгээр тухайн сум, аймгийн мал өвөлжилт, хаваржилт хүндрэхээр тогтоогдсон тохиолдолд аймаг, сумын отрын бэлчээр болон бэлчээрийн даац хүрэлцээтэй бусад аймаг, сумын нутагт малыг отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн зохион байгуулах;

2.1.10. Шинээр өвөлжөө, хаваржаа барих, бэлчээрийг гэрээгээр ашиглах малчид, малчдын анхдагч холбооны санал, Багийн Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг тус тус үндэслэж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах;

2.1.11. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад мал аж ахуйн зориулалттай худаг, хөв, өвөлжөөний ба хаваржааны хашаа, хувийн болон нийтийн зориулалттай бусад барилга байгууламжид гэм хор учруулсан бол хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцах тухай Ашигт малтмалын тухай хуулийн 41.1 дэх заалтыг чанд хэрэгжүүлэх;

2.1.12. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний салшгүй хэсэг болох бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэрийн хамт тусгаж хэрэгжүүлэх, хяналт тавих;

2.1.13. Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу тавиул мал бүхий харьяа иргэд, хуулийн этгээдээс бэлчээр ашигласны төлбөр авах, хуримтлагдсан төлбөрийг сумын бэлчээр хамгаалах, сайжруулах арга хэмжээнд зарцуулах;

2.1.14. Малын тоо толгойн татварын болон ургамал, ойн дагалдах баялаг, усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлэх;

2.2. Аймгийн Газрын албаны хэрэгжүүлэх арга хэмжээ

2.2.1. Жил бүрийн бэлчээрийн төлөв байдлын мэдээлэл /салхи, үерт эвдэгдсэн, цөлжсөн, доройтсон, талхлагдсан, өөр ангилалд шилжсэн бэлчээр/-ийг бэлчээрийн харилцаанд оролцогч /аймаг, сумын удирдлага, төрийн байгууллага, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч/-дод тухай бүр мэдээлж байх;

2.2.2. Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал"-ын дагуу бэлчээрийн ургацыг тогтоох ажлыг холбогдох төрийн байгууллага /Хүнс, хөдөө аж ахуйн газар, Ус цаг уурын газар, Байгаль орчны газар/-тай хамтран зохион байгуулах, хяналт тавих, баталгаажуулах;

2.2.3. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрээр тогтоосон улирлын, отрын, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээрийн байршил болон бэлчээр ашиглуулах гэрээ байгуулсан шийдвэрийг газрын мэдээллийн нэгдсэн санд оруулах;

2.2.4. Сумын газрын даамлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглах,

хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлттэй уялдуулан ялгаатай тусгах, биелэлтэд хяналт тавих, хариуцлага тооцох;

2.2.5. Эзэмших гэрчилгээ олгосон өвөлжөө, хаваржаа, шинээр гаргасан болон сэргээн засварласан гар болон инженерийн хийцтэй худгийн байршлыг газрын мэдээллийн нэгдсэн санд жил бүр шинэчлэн бүртгэх;

2.3 Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын хэрэгжүүлэх арга хэмжээ

2.3.1.Бэлчээр ашиглагчдад бэлчээрийн ашиглалт, хамгаалалттай холбоотой технологийн сургалтыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.3.2.Тухайн жилийн өвөл-хаврын бэлчээрийн даацыг аймгийн Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран тогтоох, мал өвөлжүүлэх, хаваржуулах арга хэмжээг аймгийн хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх,

2.3.3.Бэлчээр ашиглагчдын хүсэлт, сумын удирдлагаас ирүүлсэн шийдвэрт үндэслэн бэлчээрийн усан хангамжийг сайжруулах арга хэмжээ авах;

2.3.4.Бэлчээрийн хортон мэрэгчдийн тархалтын судалгаа хийсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулах;

2.3.5.Сүргийн бүтцийн зохистой харьцааг сум бүрээр тооцох, мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангах;

2.3.6.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс тогтоох, отрын нөөц бэлчээр бий болгох талаар сумаас хэрэгжүүлсэн/хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явцтай танилцах, тулгамдсан асуудлаар зөвлөмж гаргах, хэрэгжилтэд нь дэмжлэг үзүүлэх;

2.4. Аймгийн Байгаль орчны газар дараах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

2.4.1.Бэлчээрийн экосистемийн тэнцвэрт байдлыг хамгаалах, бэлчээрийн ургамлыг байгалийн аясаар сэргэх боломжийг бүрдүүлэх;

2.4.2.Бэлчээр ашиглах, хамгаалахад ногоон хөгжлийн зорилтыг тусгах, төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэх;

2.4.3.Тухайн сумын усны нөөц ашигласны төлбөрийн эх үүсвэрээс гадаргын болон гүний усны нөөцийг зохистой ашиглах, хомсдол, бохирдлоос хамгаалах, нөхөх арга хэмжээ, санхүүжилтийн санал боловсруулж, аймгийн Засаг даргад өргөн барих;

2.4.4.Аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдлийн биологийн зүйлийн амьдрах орчин, холбоос нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горим, зэрлэг амьтны идэш тэжээлийг харгалзсан улирлын бэлчээр, байгалийн хадланг сэлгэж хадах хуваарийг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах чиглэлээр газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт мэргэжлийн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хамтарсан хяналт тавих;

2.5. Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар дараах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

2.5.1.Бэлчээрийн төлөв байдалд ажиглалт, мониторингийн арга хэмжээ, үйл ажиллагааны зардлыг сум, аймгийн төсөвт жил бүр тусгуулах;

2.5.2.Сум, багийн түвшинд бэлчээрийн мониторинг хийх ажлыг цаг уурын өртөө, харуулын ажиглагч, техникч болон аймгийн хөдөө аж ахуйн цаг уурын инженертэй хамтран зохион байгуулах;

2.5.3.Богино, урт хугацааны цаг агаарын болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээг орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд, бэлчээр ашиглагчдад тогтмол хүргэх;

2.5.4.Ган, зудыг эртнээс сэрэмжлүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд баг

бүрээр боловсруулан гаргадаг өвөл-хаврын бэлчээрийн даац болон зудын эрсдлийн үнэлгээг орон нутгийн удирдлагууд болон бэлчээр ашиглагчдад танилцуулах;

2.5.5.Бэлчээрийн өнөөгийн төлөв байдал болон цөлжилтийн үнэлгээний мэдээллийг орон нутгийн удирдлагууд болон бэлчээр ашиглагчдад хүргэх;

2.5.6.Цөлжилтөөс сэргийлэх, цөлжилтийг сааруулах, цөлжилттэй тэмцэх талаар уламжлалт болон шинжлэх ухаанд суурилсан мэдлэгийг ард иргэдэд эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

2.6. Тусгай хамгаалалттай газрын захиргааны хэрэгжүүлэх арга хэмжээ

2.6.1.Байгаль, цаг уурын хүндрэл тохиолдсон үед дархан цаазат, байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц болон дурсгалт газар, тэдгээрийн орчны бүсэд хамгаалалтын дэглэм, горим, бэлчээрийн нөөц, даацад нийцүүлэн мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх ажлыг гэрээний үндсэн дээр харьяалах хамгаалалтын захиргаатай хамтран зохион байгуулах;

Гурав. Аймаг, сум, багийн Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.1. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг нэгтгэж, дүгнэлтийг сумын Засаг даргад хүргүүлэх;

3.1.2.Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд чиглэл өгөх;

3.1.3. Бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг сумдад хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 60.2.8, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6.2 дахь заалт, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.5 дахь заалтын дагуу шаардлагатай хөрөнгийг төсөвлөх, зарцуулалтад хяналт тавих;

3.1.4. Гэрээгээр ашиглуулж байгаа бэлчээрийн даацаас хэтэрсэн мал, малаас гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулахад аймгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын түншлэл, ашигтай зах зээлд гарах боломжид түшиглэсэн арга хэмжээ авах;

3.1.5.Төрөл бүрийн малын бордооны төрөлжсөн цэг (бэлчээр-бордох)-т арилжааны чиглэлээр түрээслүүлдэг хадлангийн талбайг олгож өвс бэлтгүүлэх болон бэлчээрт түр ашиглуулах зохицуулалт боловсруулж мөрдүүлэх,

3.1.6. Экспортод гаргах малыг бөөнөөр тусгаарлах бааз, цэг байгуулах газрын асуудлыг тухайн сум, экспортлогчдын саналыг харгалзан тогтоох, зохих арга хэмжээг үйл ажиллагааных нь чиглэлд нийцүүлэн ялгавартай мөрдүүлэх;

3.1.7. Засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн индекс тооцох аргачлал”-д заасан дараах үзүүлэлтийг сумаар тооцож аймгаар нэгтгэн дүгнэлт гаргаж байх;

3.2.Сумын Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2.1.Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барьж хэлэлцүүлэх;

3.2.2.Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөлтөд энэхүү журмыг мөрдүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үнэлэх, хянах, тайлагнах;

3.2.3.Малчин өрхийн анхдагч холбооноос бэлчээр гэрээгээр ашиглахаар гаргасан хүсэлтийг Багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт санал гаргуулах;

3.2.4.Сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан (газрын

даамал, хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн)-г оролцуулж малчдын холбооны хүсэлт, Багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг энэхүү журмын бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах заалттай нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргуулж, хяналт тавиулах;

3.2.5.Энэхүү журмын 3.2.4-д заасны дагуу гэрээ байгуулах шаардлагад нийцсэн дүгнэлт гарсан тохиолдолд бэлчээр ашиглуулах болзол, хяналт, харицлагыг тусгасан гэрээг баталгаажуулах;

3.2.6.Газрын тухай хуулийн 52.11 дэх заасны дагуу гэрээгээр ашиглуулж байгаа бэлчээрийг хашихыг хориглох заалтыг сумын хэмжээнд хэрэгжүүлэх, энэ тухай бэлчээр ашиглуулах гэрээнд тодорхой тусгах;

3.2.7.Нийтээр ашиглах бэлчээрт зөвшөөрөлгүйгээр хашаа, саравч барьсан, бэлчээрийг хашсан тохиолдолд албадан буулгах ажлыг нэн даруй хэрэгжүүлэх;

3.2.8.Өөр аймаг, сумаас отроор мал өвөлжүүлж хаваржуулах тохиолдолд энэхүү журам болон холбогдох зохицуулалтыг мөрдөх;

3.2.9.Үндсэн харьяаллын бус мал бүхий иргэд, хуулийн этгээдийн малыг тухайн сумын нутгаас гаргах ажлыг үе шаттай зохион байгуулж, бэлчээр чөлөөлөх, сэргээх арга хэмжээ авах;

3.2.10.Сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн дүйцүүлэн хамгаалах зардлыг бэлчээрт худаг гаргах, хөв цөөрөм байгуулах, хадлангийн талбай сайжруулах, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээнд зарцуулах;

3.2.11.Сумын хилийн цэсийн дагуу нутаглаж буй малчин өрхийн бэлчээр ашиглах эрхийг хөндөхгүйгээр нутаг дэвсгэрийн нэгжийн харьяаллын дагуу өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх;

3.3.Багийн Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээ

3.3.1.Сумын Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэхүү журмыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэх;

3.3.2.Бэлчээр ашиглах, хамгаалах журмыг багийн иргэдэд сурталчлах, таниулах;

3.3.3.Малчдын холбоодоос сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар санал болгосон бэлчээр ашиглах, хамгаалах арга хэмжээг Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргах;

3.3.4.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад малчдын оролцоог бүрэн хангах, төлөвлөгөөний хэрэгжилтийг багийн хэмжээнд зохион байгуулах, тайлагнах;

3.4 Малчин өрхийн анхдагч холбооны хэрэгжүүлэх арга хэмжээ

3.4.1.Энэхүү журмыг малчин өрхийн анхдагч холбооны гишүүн өрх бүр мөрдөн хэрэгжүүлэх;

3.4.2. Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтын дагуу бэлчээр ашиглуулах гэрээг малчин өрхийн анхдагч холбооны бүх гишүүн малчин өрхийг хамруулан байгуулах;

3.4.3.Малын тоо, төрлийг гэрээгээр ашиглаж буй бэлчээрийн даацад тохируулах талаар гэрээгээр хүлээсэн үүргийг малчдын анхдагч холбоо, гишүүн өрх бүр биелүүлэх;

3.4.4.Малын тоог тухайн жилийн даацаас хэтрүүлсэн бол хэтэрсэн тооны малыг бэлчээр ашиглуулах гэрээнд заасны дагуу борлуулах арга хэмжээ авах;

3.4.5.Сум, багийн иргэдийн хурал, бэлчээрийн асуудлаар санал боловсруулах хэлэлцүүлэг, бусад арга хэмжээнд идэвхтэй оролцох;

3.4.6.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ /бэлчээр сэлгэх, өнжөөх, худаг гаргах, хөв цөөрөм байгуулах, хортон мэрэгчидтэй тэмцэх/-ний саналыг шаардагдах санхүүжилт хэмжээ, эх үүсвэрийн хамт сумын Засаг даргад хүргүүлэх;

Дөрөв. Бэлчээр ашиглах, хамгаалах журмыг хэрэгжүүлэх чиглэлээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай харилцах, хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.1.Аймгийн бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журмын төслийг хэлэлцэж батлах;

4.1.2.Иргэдийн төлөөлөгчдийн хурал баталсан журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх;

4.1.3.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

4.1.4.Бэлчээр ашиглах, хамгаалахтай холбогдох зардлыг аймгийн холбогдох мэргэжлийн байгууллага, сумын төсөвт тусгуулах, батлах;

4.2.Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хэрэгжүүлэх арга хэмжээ

4.2.1.Бэлчээр ашиглуулах гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн, журмыг удаа дараа зөрчсөн этгээдийн бэлчээр ашиглуулах гэрээг цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэхийг Засаг даргад үүрэг болгох;

4.2.2.Багийн иргэдийн нийтийн хурлаас энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч буй арга хэмжээ, түүний биелэлтэд хяналт тавих;

4.2.3. Малын тоо толгойн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөр, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн төлсөн бэлчээр ашигласны төлбөрийн тодорхой хувийг бэлчээр ашиглах, хамгаалахтай холбогдон хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулахаар сумын төсөвт тусгаж батлуулах;

4.3.Багийн Иргэдийн нийтийн Хурлын хэрэгжүүлэх арга хэмжээ

4.3.1. Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах бэлчээр ашиглах, хамгаалах арга хэмжээний саналыг хэлэлцэн шийдвэр гаргах;

4.3.2.Бэлчээр хамгаалах, ашиглах арга хэмжээг багийн хэмжээнд хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих;

Тав.Бэлчээр ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хэрэгжүүлэх тусгай арга хэмжээ

5.1.Бэлчээр ашиглуулах

Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн холбогдох заалтын дагуу бэлчээр, түүнийг зохистой ашиглах, хамгаалахад чиглэсэн дараах арга хэмжээг энэхүү журмын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд

5.1.1.Бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон сумын тухайн жилийн төлөвлөгөөнд үе шаттай төлөвлөж, хэрэгжүүлэх;

5.1.2.Бэлчээрийг өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн улирлын хуваариар, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, уст цэг, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглах;

5.1.3. Багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга бэлчээрийг Малчин өрхийн анхдагч холбоонд болзолт гэрээгээр ашиглуулах арга хэмжээг нийтлэгээр хэрэгжүүлэх;

5.1.4.Нүүдлийн зэрлэг амьтдын холбоос нутгаар дамжин өнгөрөх, төллөх хугацаанд бэлчээрийг түр хугацаанд чөлөөлөх;

5.1.5.Тухайн сумын нутаг дахь тусгай хамгаалалттай газар нутгийн бэлчээр ашиглалтыг “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-ийн 29.2 дахь заалтад нийцүүлэн хамгааллын горимын дагуу зохицуулах;

5.2.Бэлчээр хамгаалах

5.2.1.Сумын отрын бүс нутаг байгуулах асуудлыг малчин өрхийн анхдагч холбоо, , багийн Иргэдийн нийтийн хурлын саналыг харгалзан шийдвэрлэх;

5.2.2.Сум бүр нийт бэлчээрийн 10 хүртэл хувьтай тэнцэх нөөц бэлчээр бий болгох;

5.2.3.Монгол улсын нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.2 дахь заалтын дагуу мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоох;

5.2.4.Атаршсан газрыг дахин ашиглах зорилгоор малчин өрхийн анхдагч холбоонд малын тэжээлийн ургамал тариалах, эрчимжсэн мал аж ахуйд ашиглах таримал бэлчээр бий болгох зориулалтаар малчин өрхийн анхдагч холбоонд олгох;

5.2.5.Өөр аймаг, сумын малчдад өвөлжөө, хаваржаа, хонд бууцыг ашиглуулах, түрээслэх, төлбөр авахыг хориглох;

5.2.6.Тухайн улиралд ашиглахаар тогтоосноос бусад бэлчээр, хадлангийн талбай, түүний ойр орчимд нутаглах, мал бэлчээхгүй байх;

5.2.7.Тариалангийн талбай бүхий газар өвөлжөө, хаваржааны газар олгох, нутаглах, мал бэлчээхэд Тариалангийн тухай хуулийн 24.2 дахь заалтыг мөрдөх

5.2.8.Зуслан, намаржааны бэлчээр болон сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд зааснаас өөр газар албан ёсны зөвшөрөөлгүйгээр өвөлжөө, хаваржаа барихыг хориглох;

5.2.9.Бэлчээрийн мэрэгч, хортон шавжтай тэмцэх болон ургамал хамгаалах химийн бодис, бордоо хэрэглэх арга хэмжээг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хууль”-ийн17.3.2 ба 18.4 дэх заалтад заасны дагуу хэрэгжүүлэх

5.2.10.Бэлчээрийн талхлагдлыг бууруулах, хамгаалах, сайжруулах зорилгоор харь зүйлийн ургамал тариалахыг хориглох;

5.1.11.Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалах;

5.1.12.Зүүн бүсийг хөдөө аж ахуйн төрөлжсөн дэд бүс болгон хөгжүүлэх бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, малчдын хоршоонд 5 га газар эзэмшүүлэх тухай Газрын тухай хуулийн 33.1.2 дахь хэсэг, “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээний үр дүнд мал аж ахуйг эрчимтэй болон хагас эрчимжсэн технологиор эрхлэхэд зориулж эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсийг шинэчлэх, шинээр тогтоох арга хэмжээг сум бүр авах;

5.1.13.Зун, намрын бэлчээрт өвөлжөө, хаваржааны зориулалтаар хашаа, саравч барихыг хориглох;

5.1.14.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан сэлгэх, өнжөөх бэлчээрт нутагласан, мал оруулсан этгээдэд хариуцлага тооцох;

Зургаа.Санхүүжилт

6.1.Санхүүгийн эх үүсвэр

6.1.1.Улсын төсөв;

6.1.2.Орон нутгийн төсөв (малын тоо толгойн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөр, газрын төлбөр, мал бүхий иргэн, хуулийн этгээдийн бэлчээр ашигласны төлбөр, тусгай хамгаалалттай газар нутгийн бэлчээрийн төлбөр);

6.1.3.Олон улсын төсөл, хөтөлбөр;

6.1.4.Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалт;

6.1.5.Бусад.

6.2.Зарцуулалт

6.2.1.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг малчдын оролцоог хангах, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилт, хугацааг тодорхой тогтоох;

6.2.2.Бэлчээр ашиглагчдыг мэдээллээр хангах, журмыг сурталчлах чиглэлээр сургалт, танин мэдэхүйн арга хэмжээг хагас жил тутам зохион байгуулах;

6.2.3.Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажил, төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагааны зардлыг газрын даамал Хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран тооцож төлөвлөгөөнд тусгана. Шаардлагатай гэж үзвэл дараах албан тушаалтныг хамруулна. Үүнд:

- Газрын даамал
- Хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн
- Цаг уурч, харуул
- Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Багийн засаг дарга

6.2.4.Доор дурдсан санхүүжилтийг техник эдийн засгийн үндэслэл болон холбогдох журмын дагуу тооцно.

- Худаг гаргах, сэргээх,
- Хөв цөөрөм байгуулах;
- Хортон мэрэгчидтэй тэмцэх, сэг зэм, хог хаягдал цэвэрлэх;
- Бусад.

Долоо.Журмын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох

7.1.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох саналыг Засаг даргад уламжилна.

7.2.Энэхүү журмыг зөрчсөн бэлчээр ашиглагчдад Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг үндэслэн байгаль орчны хяналтын улсын байцаагч, хамгаалалтын захиргааны хамгаалалт хариуцсан ажилтан (Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд хяналтын улсын байцаагчийн эрхтэй хэмээн заасан) хариуцлага хүлээлгэнэ.

Найм.Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх

8.1.Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт заасны дагуу бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой гарсан маргааныг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

8.2.Энэхүү журмыг зөрчиж бэлчээр, ус, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Зөрчлийн тухай хуулийн 8.1, Усны тухай хуулийн 7.15 дах заалтын дагуу зохицуулна.

Ес.Журам хүчин төгөлдөр болох

9.1.Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт заасны дагуу журмыг Захиргааны хэм хэмжээний актыг улсын бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.

- --o0o-- -